

2011 оны 3-р сар



# Баримтын товчоон

- Оюу Толгойн тухай
- Монгол улсад Монголчуудад
- Монгол улсын Эдийн засгийг хүчирхэгжүүлэх
- Орон нутгийг дэмжих
- Говийн бүсийн байгаль хамгаалал
- Оюу Толгой Хөрөнгө оруулалтын гэрээ

# ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ



**Оюу Толгойн уурхайн бүтээн байгуулалтын ажил 2010 оны 4-р сард эхэллээ. 2012 оны эцэс гэхэд олборлолтоо эхэлснээр Оюу Толгой нь агуулга өндөртэй зэс-алтны дэлхийн томоохон уул уурхайнуудын нэг болох юм.**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос 600 км зайтай Өмнөговь аймагт орших Оюу Толгой ордыг 2001 онд Айвенхоу Майнз компани нээсэн.

Монгол Улсын Засгийн газар (34%), Айвенхоу Майнз болон Рио Тинто 2009 оны 10-р сарын 6-ний өдөр Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж, 2010 оны 3-р сарын 31-нд хүчин төгөлдөр болсноор Монголын уул уурхайн Оюу Толгой компани байгуулагдсан.

## Монголын түүхэн дэх томоохон бүтээн байгуулалт

Доод тал нь 56 жил ашиглалт явуулах Оюу Толгой төслийн анхны капитал хөрөнгө оруулалтыг доод тал нь 7.1 триллион төгрөг (5 тэрбум ам. доллар) гэж тооцоолж байгаа нь Монголын түүхэн дэх томоохон бүтээн байгуулалт төдийгүй гадаадын хөрөнгө оруулалтын төсөл.

Оюу Толгойн уурхай нь бүрэн ашиглалтанд орсноор Монгол улсын ДНБ-ийг 30 гаруй хувиар нэмэгдүүлж, 3000 гаруй иргэн байнгын ажлын байртай болох юм.


## Оюу Толгой 2012 оны эцэс гэхэд олборлолтоо эхэлнэ

**1-р шатанд:** Оюу Толгойн ил уурхайн олборлолт 2012 онд эхэлнэ.

**2-р шатанд:** Гүний уурхайн олборлолтыг 2015 оноос эхлүүлнэ. 2020 онд Оюу Толгой бүрэн хүчин чадлаар ажиллахаар төлөвлөгдөөд байгаа болно.

2010-2013 онуудад 5.6 триллион төгрөгийн (4 тэрбум ам доллар) төсөвтэй дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Үүнд:

- Ил уурхай;
- Хүдэр боловсруулах үйлдвэр (Баяжуулах үйлдвэр);
- Төслийн талбайн дэд бүтэц, орон сууц;
- Хөндлөн малталт.



## ОНЦЛОХ БАРИМТУУД

Оюу Толгой бол дэлхийн томоохон зэс-алтны орд юм.

Оюу Толгойн зэс-алтыг олборлож эхлэхээс өмнө 7.1 триллион төгрөгийн (5 тэрбум ам. доллар) хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Оюу Толгойн олборлолт эхэлснээр Монгол улсын Засгийн газар нийт орлогын 54%-ийг татвар, хураамж, хувь эзэмшлийн хэлбэрээр авна.

Оюу Толгойн уурхай дэлхийн хамгийн ашигтай зэсийн уурхайнуудын нэг болох юм.

Оюу Толгойд дэлхийн шилдэг технологи, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, байгаль орчны хэм хэмжээ, стандартыг мөрдөнө.

# ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ



## Он цагийн бичээс

**2001 оны 7 сар:** Айвенхоу Майнз Оюу Толгойн бүлэг ордын эхнийхийг нээв.

**2006 оны 10 сар:** Айвенхоу Майнз болон Рио Тинто стратегийн түншлэл байгуулж Оюу Толгойн барилгын болон ашиглалтыг хариуцах хамтарсан техникийн зөвлөл байгуулав.

**2008 оны 1 сар:** 6.7 метрийн диаметртэй 1-р Босоо амны нэвтрэлтийг хийж 1385 метрийн гүнд хүрсэн. Энэ нь Монгол улс дахь хамгийн гүнд тооцогдох босоо ам төдийгүй Азид гүнд тооцогдох босоо амуудын нэг юм. Энэхүү босоо ам нь нэмэлт хайгуул, хүдэр гаргах мөн агааржуулалтын зориулалтаар ашиглагдах болно.

**2009 оны 10 сар:** Рио Тинто Айвенхоу Майнз эзэмших хувь хэмжээгээ нэг дахин нэмэгдүүлж 19.7%-д хүргэв.

**2010 оны 3 сар:** Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээгээр Монгол улсын Засгийн газар 34%-ийг эзэмшихээр болов. Рио Тинто Айвенхоу Майнз дахь хувь эзэмшлээ 22.4%-т хүргэв.

**2010 оны 6 сар:** 10 метрийн диаметртэй 2-р Босоо амны ажлыг сэргээлээ. Энэ босоо ам нь гүний уурхайн олборлолтын болон үйлчилгээний зориулалттай.

**2010 оны 7 сар:** Оюу Толгой ХХК Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж боловсрол, сургалтын хөтөлбөрүүдэд ирэх 5 жилд 78 тэрбум төгрөг (58 сая ам.доллар)-ийн хөрөнгө оруулалт хийхээр болов.

**2010 оны 7 сар:** 1.6 триллион төгрөг (1.2 тэрбум ам доллар)-ын төсөвтэй хүдэр баяжуулах үйлдвэрийн суурийг тавьж эхлэв.

**2010 оны 12 сар:** Рио Тинто Айвенхоу Майнз дахь хувь эзэмшлээ 40.5%-т хүргэв.

**2012:** Ил уурхайн ашиглалт эхэлнэ. Чулуулгийг зайлуулж, хүдрийн биетэд хүрнэ.

**2012:** Баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулав.

**2015:** Блокчлон олборлох аргаар гүний ордын олборлолтыг эхлүүлнэ. Өртөг өндөртэй, техникийн цогц шийдэл шаардсан гүний уурхайн олборлолтын энэ арга нь газрын гүнд байгаа Оюу Толгойн бүлэг ордод тохиромжтой. Газрын гүнд байрлах хүдрийн биетийн доогуур тохирсон, тусгайлан загварчилсан малталт хийж өгснөөр хүдэр өөрийн массаар доош унадаг. "Агуй"-г гаргасны дараа хүдэр доош унах ба тэндээс хүдрийг авч, газрын гадаргууд гарган боловсруулдаг.

## ИРЭЭДҮЙ:

Өнөөдрийг хүртэл хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд Оюу Толгойг эдийн засгийн хувьд ашиглаж болохоор уурхай болно гэж тогтоосон юм. Оюу Толгой ХХК болон бусад компаниудын хийж байгаа хайгуулын ажил нь Монгол улсад бусад төслүүдийг хэрэгжүүлэх, эдийн засгийг өсгөх, шинэ ажлын байр нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт хийнэ.

## Монгол улсын үр ашгийг урт удаан хугацаанд хангах

Оюу Толгой ХХК нь байгаль орчин, өөрийн ажилтан ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарч, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, чин шударгаар үйл ажиллагаагаа явуулахыг эрхэмлэдэг.

Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа иргэдтэй хамтран ажиллаж, хууль дүрэм, зан заншлаан эрхэмлэн сахиж, өөрийн хийж буй хөрөнгө оруулалтаар Монгол улс, Монгол улсын иргэддээ эрх тэгш үр ашгийг хангахын төлөө ажилладаг.

# МОНГОЛ УЛСАД МОНГОЛЧУУДАД



Өнөөдөр Оюу Толгой төсөлд 6000 аас доошгүй тооны ажилчид болоод гэрээт ажилтан ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 68% хувь буюу 3900 гаруй нь Монголчууд юм. Үүнээс 1000 гаруй нь Өмнөговь аймгийн харьяат иргэд байна.

Бид Монгол иргэдийг ажлын байраар хангах бодлогыг эрхэмлэдэг бөгөөд үүнд:

- Барилгын шатанд ажиллах нийт хүчний 60 хувь нь Монгол иргэд байх;
- Доод тал нь 56 жил үйл ажиллагаа явуулах энэхүү уурхайн олборлолт эхлэхэд тус компани ажилчдын 90 хувь нь Монгол иргэд байх зорилготойгоор ажиллаж байна.

Бид олон улсад өрсөлдөхүйц уул уурхайн мэргэжилтэн бэлтгэхийн төлөө боловсрол, сургалтад хөрөнгө оруулалт хийнэ.

## Оюу Толгойн шаардлага хангах мэргэжилтэн бэлтгэх

Боловсролын салбарт хийж буй бидний хөрөнгө оруулалт нь дотоодын боловсон хүчин бэлтгэх бидний зорилгыг хангаад зогсохгүй дараах чиглэлээр өндөр ур чадвартай, техникийн мэргэшсэн үндэсний боловсон хүчнийг бий болгоно.


- Механик;
- Хүнд даацын тоног төхөөрөмжийн оператор;
- Засвар үйлчилгээ;
- Уул уурхай;
- Металлурги;
- Баяжуулах;
- Геологи;
- Инженер;
- Хүний нөөц, сургалт;
- Эрүүл мэнд, аюулгүй байдал;
- Байгаль орчны судалгаа;
- Санхүү, эдийн засаг;
- Мэдээллийн технологи;
- Хөрөнгийн менежмент.

Оюу Толгой ХХК-ийн мөрдөж буй энэ бодлогыг 2010 оны 7 дугаар сард Засгийн газартай хийсэн харилцан ойлголцлын санамж бичигт заасан болно (дэлгэрэнгүйг дараагийн хуудаснаас үзнэ үү).

## МОНГОЛЧУУДАД ДАВУУ ЭРХ ОЛГОХ САНААЧЛАГА – МОНГОЛЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ЭН ТЭРГҮҮНД

Монголчуудад давуу эрх олгох санаачлага нь хангамжийн тал дээр бидний баримталж буй үндсэн бодлого бөгөөд орон нутгийн компаниудыг дэмжих, хөгжүүлэх, нэн хурдацтай өргөжиж байгаа Монголын зах зээл дээр өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэхэд оршиж байна.

Өнөөдрийг хүртэл бид 2520 гаруй Монголын ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж байгаагаас манай нийт гэрээний 80 хувийг гэрээлж хамтран ажиллаж байна.



# МОНГОЛ УЛСАД МОНГОЛЧУУДАД



## Ирээдүйн төлөө хийж буй бидний хөрөнгө оруулалт

2010 оны 7-р сард Оюу Толгой ХХК болон Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам боловсрол, сургалтын талаарх Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан болно.

Энэхүү санамж бичгээр Оюу Толгой ХХК Монгол улсын Оюу Толгой төсөл болон уул уурхайн бусад төслүүдэд ажиллах Монголын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд 78 тэрбум төгрөгийн (58 сая ам долларын) хөрөнгө оруулалтыг ирэх 5 жилийн хугацаанд хийхээр болсон юм.

Оюу Толгой ХХК-аас:

- 30 сая ам доллар 5 жилийн сургалтын төлөвлөгөөнд;
- 11.3 сая ам доллар Өмнөговь аймгийн Даланзадгад сум болон Улаанбаатар хотод уул уурхайн сургууль шинээр байгуулах;
- 10 сая ам доллар Монголын их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүдэд суралцах 200 оюутны, гадаадад уул уурхайн чиглэлээр суралцах 30 оюутны тэтгэлэгт хөтөлбөрт;
- 6.5 сая ам доллар Эрдэнэт, Улаанбаатар, Дархан болон Чойрын сургалтын төвүүдийн тоног төхөөрөмжийг сайжруулах, хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхэд зарцуулах юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮР АШГИЙГ УРТ УДААН ХУГАЦААНД ХАНГАХ

Оюу Толгой ХХК нь байгаль орчин, өөрийн ажилтан ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарч, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, чин шударгаар үйл ажиллагаагаа явуулахыг эрхэмлэдэг.

Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, хууль журам, зан заншлыг эрхэмлэн мөрдөж, өөрийн хийж буй хөрөнгө оруулалтаар Монгол улс, иргэдэд эрх тэгш үр ашгийг хангахын төлөө ажилладаг.

## Онцлох баримт

Оюу Толгойн уурхай ашиглалтад орсноор тус уурхайд 3000 - 3500 хүн ажиллана.

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ



## Хувь эзэмшил

2009 оны 10-р сарын 6-ны өдөр зурагдсан Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Монгол улсын засгийн газар Оюу Толгойн 34%-ийг эзэмшдэг.

Монгол улсын эдийн засагт Оюу Толгой ХХК дараахи хэлбэрүүдийн хөрөнгө оруулалтуудыг хийдэг. Үүнд:

## Татварын орлого

Оюу Толгой ХХК нь Монгол улсын Засгийн газарт ААН-ийн татвар, орлогын албан татвар, лицензын болон бусад татвар хураамжуудыг төлдөг.

2000 оноос 2010 оны хооронд Оюу Толгой ХХК татвар хураамжид нийт 73.5 тэрбум төгрөг (57.8 сая ам доллар), мөн Монгол улсын Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт лицензийн төлбөрт 26.6 тэрбум төгрөг (22.1 сая ам.доллар) төлөөд байна.

## Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах

Оюу Толгойн геологи хайгуулын нээлт, ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ нь гадаадын жижиг, том олон компаниудын анхаарлыг Монгол улс руу татсан билээ.

2009 оны байдлаар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 30%-ийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бөгөөд улсын нийт экспортын 75,8%-ийг тус салбарын бүтээгдэхүүн эзэлсэн байна.

## Дэд бүтэц

Оюу Толгой нь Монгол улсын эдийн засгийн аж үйлдвэрийн болон үйлдвэрлэлийн салбарыг өргөжүүлэн хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэх болно.

Хөгжлийн явцад орон нутаг, бүсийн дэд бүтцэд нэлээдгүй хөрөнгө оруулалт хийгдэхийн дотор авто замын шинэ сүлжээ, суурин газар болон дагалдах дэд бүтцийг төлөвлөөд байна.

## Монголын ханган нийлүүлэгчид, ажлын байр, сургалт

Оюу Толгой ХХК нь:

- Монголын иргэдийг ажлын байраар хангах,
- Орон нутгийн ханган нийлүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Боловсрол сургалт, хөгжлийн чиглэлээр томоохон хөрөнгө оруулалтыг хийхээр ажиллаж байна.

2010 оны 7-р сард Оюу Толгой ХХК, Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамтай боловсрол сургалтын талаар Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав. Энэхүү баримт бичгээр ирэх 5 жилд Монголын боловсон хүчнийг сургахад 78 тэрбум төгрөг (58 сая ам доллар)-ийн хөрөнгө оруулалт хийхээр болсон юм.



## Байгаль орчныг хамгаалж, орон нутгийг дэмжинэ

Оюу Толгой ХХК :

- Говь нутгийн байгаль орчныг хамгаалах;
- Усны хариуцлагатай менежмент хийх
- Орон нутгийг дэмжих хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж байна.

# ОРОН НУТГИЙГ ДЭМЖИХ



**Оюу Толгойн уурхай нь Өмнөговь аймгийг Монголын тэргүүлэгч аж үйлдвэр, уул уурхайн төв болоход хувь нэмрээ оруулна.**

Аж үйлдвэрийн болон мэдлэгт суурилсан салбаруудын хөгжил дэвшил нь бүс нутгийн нийгмийн болон үйлдвэрлэлийн салбарын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Эдийн засгийн өсөлтийн явцад орон нутагт орох үр ашгийг нэмэгдүүлэх, урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг хангах нь онцгой ач холбогдолтой юм.

Оюу Толгой ХХК Өмнөговь аймгийн хөгжлийг дэмжих зорилгоор доорхи хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

- Боловсролын хөтөлбөр;
- Эрүүл мэндийн хөтөлбөр;
- Нийгэм, соёлын хөгжлийн хөтөлбөр;
- Орон нутгийн бизнесийг хөгжүүлэн дэмжих хөтөлбөр;
- Орон нутгийн дэд бүтцийг сайжруулах хөтөлбөр;
- Малчдыг дэмжих төсөл хөтөлбөрүүд;
- Байгаль орчны мониторингийн хөтөлбөрүүд.

## **Орон нутгийг дэмжих санаачлагууд**

**Оюу Толгой ХХК хөгжлийн санаачлагуудыг санхүүжүүлэх, төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар орон нутаг болон Монгол улсад хөрөнгө оруулалт хийж байна.**



## **Бидний санаачилж хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд:**

### **Өмнөговь аймгийн хүний нөөцийг дэмжих хөтөлбөр:**

Өмнөговь аймгийн харьяат 134 оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж Монголын их дээд сургуулиудад суралцав.

### **Эрүүл мэндийн хөтөлбөр:**

Өмнөговь аймгийн сумдуудын эмчийг орон сууцаар хангаж, тус аймгийн 11 суманд 20 эмчийг 5 жилийн хугацаат гэрээгээр ажиллуулж байна.



# ГОВИЙН БҮСИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ



**Оюу Толгой төслийн барилгын болон олборлолтын шатанд Өмнийн Говийн бүсийг хайрлан хамгаалах, Монгол орны ирээдүйн эздэд байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалж үлдээхэд онцгойлон анхаарч үйл ажиллагаагаа төлөвлөж байна.** Үүнд:

- Уул уурхайн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын стандартуудад үйл ажиллагаагаа нийцүүлэх;
- Баруун Европын дэвшилтэт хууль зүйн системд суурилсан Монгол Улсын Байгаль орчны хууль, стандартуудыг хангаж ажиллах;
- Дэлхийн Банкнаас олон улсын эрдэс баялгийн салбарт зориулан боловсруулсан стандартуудыг мөрдөх гэсэн үйл ажиллагаанууд багтана.

## **Монгол Улсын стандартуудыг мөрдөж тогтмол хяналтыг хэрэгжүүлнэ**

Оюу Толгой төсөл Байгаль орчны суурь судалгааг 2002 оны 5 дугаар сард эхлүүлж Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд өргөн барьсан. Ингэснээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) болон Байгаль Орчныг Хамгаалах Төлөвлөгөөг (БОХТ) боловсруулах ажлыг албан ёсоор

эхлүүлсэн.

Энэхүү ажил нь 2003 оны сүүлчээр Айвенхоу Майнз компани ашигт малтмалын лицензийг шилжүүлж авснаас хойш Монгол Улсын Ашигт Малтмалын Хуулийн дагуу үргэлжилсэн. 2004 оны 4 дүгээр сард Засгийн Газар БОНБУ-ний гурван хэсгийн эхний бүлгийг баталсан. Үлдсэн бүлгүүдийг 2005 онд Засгийн Газарт өргөн барьж 2007 оны 12 дугаар сард батлуулсан.

2003 оноос эхлэн Оюу Толгой төсөл Өмнийн Говийн бүс нутагт байгаль орчны мониторингийн ажлыг хийж ирсэн. Энэ ажил нь гадаргын болон гүний усны түвшинг тогтоох, ургамлын төрөл зүйл түүний чанар, тоосны хэмжээ зэргийг хамаарч байна.

Оюу Толгой нь өөрийн үйл ажиллагааг олон улсын байгаль орчны менежментийн стандартуудад нийцүүлэхийг зорьж ажилладаг.

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг 2004 оны эхээр ISO 14001 шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн.

Мөн Ашигт Малтмалын Хуульд заасны дагуу Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж орон нутгийн засаг захиргаа болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд хүргүүлж ажиллаж байна.

## **Зорилт: Шууд хаягдлыг тэглэх**

Оюу Толгой уурхай түүний баяжуулах үйлдвэр нь шууд хаягдлыг тэглэх зорилгын хүрээнд ажиллана. Энэ нь уурхайн ямар ч хаягдал ус төслийн талбайгаас хаягдах ёсгүй гэсэн үг юм.

Мөн уурхайн үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй тоосыг хянах тусгай төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

Баяжуулах үйлдвэрт ашиглагдан хаягдлын санд тунасан усыг дахин эргүүлж ашиглана. Мөн ахуйн хаягдал усыг хүдэр баяжуулахад ашиглана.



# ГОВИЙН БҮСИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ



## Усыг үр ашигтай ашиглах нь


Ус бол байгалийн хамгийн үнэ цэнэтэй баялгийн нэг билээ. Ус нь Оюу Толгой зэрэг уул уурхайн төслийн үйл ажиллагааны чухал хэсэг бөгөөд орон нутгийн иргэдийн амин чухал хэрэгцээ юм.

Бид Өмнийн Говийн бүсийн орон нутгийн иргэд, тэдгээрийн мал сүрэгт хүртээмжтэй усны их үүсвэрийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд анхаардаг. Оюу Толгой төсөл усны шинэ эх үүсвэрийг илрүүлэв

Гүний усыг ашиглах чиглэлээр ажилладаг Монголын эрх бүхий, бие даасан шинжээчдээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгүүлсэн.

Энэ нь Монгол Улсын холбогдох хуулийн дагуу барилгын шатны ажлыг эхлүүлэхээс өмнө хийгдсэн. Уг үнэлгээнүүдийг 2005 оны 9 дүгээр сард Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд өргөн барьсан.

Оюу Толгой төсөл гүний болон гадаргын усны чанар, түвшин, хандлагыг судлах судалгааг 2003 оноос эхлүүлсэн. Судалгааны үр дүнгийн хэлэлцүүлгийг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулж богино болон урт хугацаанд усны хангамж, чанарыг дээд түвшинд байлгахад анхаарч байна.



## ОНЦЛОХ БАРИМТУУД

Оюу Толгой төсөл нь Монгол орон, Өмнийн Говийн тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг.

Оюу Толгой төсөл нь Монгол улс, олон улсын стандартуудыг хангахыг зорьж ажилладаг.

Тоос, усны чиглэлээр хийгдэж буй мониторингийн ажлын үр дүнг Монгол Улсын Засгийн Газар болон орон нутгийн засаг захиргаанд хүргүүлж өөрийн үйл ажиллагаанд тусгаж ажилладаг.

Бид Өмнийн Говийн бүсийн орон нутгийн иргэд, тэдгээрийн мал сүрэгт хүртээмжтэй усны дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд анхаардаг.

Оюу Толгой төсөл үйлдвэрийнхээ усны эх үүсвэрийг бие даан нээж илрүүлсэн.

# ОЮУ ТОЛГОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ



**2009 оны 10-р сарын 6-нд Монгол Улсын Засгийн Газар Оюу Толгойн ашиглалт, үйл ажиллагааны Хөрөнгө Оруулалтын цогц гэрээг**

**байгуулсан бөгөөд уг гэрээгээр Засгийн газар уг төслийн 34%-ийг эзэмшигч болсон. Хөрөнгө Оруулалтын гэрээ нь Монгол улсын болон Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн цаашдын хөгжлийг баталгаажуулахад үнэтэй хувь нэмэр оруулах төслийн тодорхой, тогтвортой үйл ажиллагааны хүрээг бий болгосон болно.**

Энэхүү баримтанд Хөрөнгө Оруулалтын Гэрээний зүйл заалтууд, Оюу Толгойн ирээдүй болон түүний Монгол улсын хувьд гүйцэтгэх үүргийг тусгасан болно.

## **Бүтээн байгуулалт, барилгын цогц ажлыг эхлүүллээ**

Хөрөнгө Оруулалтын гэрээг эцэслэн баталснаар 7.1 триллион төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий томоохон хэмжээний бүтээн байгуулалт, барилгын ажлыг эхлүүллээд байна. Ингэснээр 2012 оны эцэс гэхэд зэсийн баяжмалыг үйлдвэрлэж эхлэх нөхцлийг хангаж байгаа юм. Одоогоор төлөвлөгдөн гүйцэтгэгдэж буй барилгын ажлууд:

- Далд уурхайн хоёрдугаар босоо ам болон түүний 31 давхар бетон цамхагийн ажил;
- Өдөрт 100,00 тонн хүдэр боловсруулах баяжуулах үйлдвэрийн суурийн ажил;
- 34-мегаваттын дизель цахилгаан станц болон 35 киловольтын дамжуулах сүлжээ;
- Ил уурхайн газар шорооны анхан шатны ажил;
- Нэгдүгээр босоо амын хөндлөн малталт;
- Монгол – Хятадын хил хүртэлх 105 км авто зам;
- Орон нутгийн нисэх буудал болон Боинг 737 нисэх онгоц буух хатуу хучилттай замын зурвасын барилгын ажил.

• Хэрэгжиж эхэлсэн төслүүдийг тэмдэглэсэн болно.

## **ЧУХАЛ БАРИМТУУД**

Монгол Улсын Засгийн Газар Оюу Толгойн 34%-ийг эзэмшдэг.

Хөрөнгө Оруулалтын гэрээг баталснаар Оюу Толгой төслийн барилгын ажлын төсвийг 5 тэрбум ам.долларын өртөгтэйгээр батлуулсан болно.

Оюу Толгой нь дэлхийн хамгийн том олборлолт эхлээгүй зэсийн ордуудын нэг болно.

Оюу Толгойд бий болж буй нэг ажлын байрны ард холбогдох салбаруудад дөрвөн ажлын байр бий болно гэж тооцоолсон.

Судалгаанаас үзэхэд Оюу Толгой нь Монгол улсын ДНБ –ний 30 гаруй хувийг эзлэхээр байна. Оюу Толгой ХХК Монголын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд ирэх 5 жилийн хугацаанд 78 тэрбум төгрөг (58 сая ам. доллар)-ын хөрөнгө оруулалт хийнэ.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, ХАМГААЛАЛ**

Хөрөнгө Оруулалтын гэрээний дагуу Оюу Толгой нь байгаль орчны менежменттэй холбоотой дээд зэргийн стандартыг дагаж мөрдөнө:

- Усны хамгаалалт, дахин боловсруулалтын шилдэг туршлага;
- Байгаль орчны нөлөөллийг бууруулах үр дүнтэй хэлбэрээр олборлолтын үйл ажиллагааг явуулах;
- Уурхайн талбайн нөхөн сэргээлт.

## ОЮУ ТОЛГОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ



“Хөрөнгө Оруулалтын Гэрээ нь Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилд томоохон ахиц гарах боломж олгохын сацуу том хэмжээний дэд бүтцийн төслүүд, хот суурин газруудыг бий болгож Монгол айл өрхүүдийн амьдралыг сайжруулна.”

- Монгол улсын Засгийн газар Хөрөнгө Оруулалтын Гэрээг эцэслэн батлах үеэр

### Монгол улсын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд оруулах хөрөнгө оруулалт

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд төсөлд ажиллах Монголын чадварлаг боловсон хүчнийг бий болгох цогц суурийг тусгаж өгсөн.

Гэрээнд заасны дагуу Оюу Толгой нь барилгын үе шатанд ажиллах хүчний 60%-ийг Монголчуудаар, цаашид энэхүү хувийг нэмэгдүүлж үйлдвэрлэлийн явцад 90%-ийг нь Монголчууд болгон бүрдүүлэхээр зорьж ажиллаж байгаа.

### Боловсрол болон сургалтанд зориулагдах хөрөнгө оруулалт

Техникийн өндөр ур чадвартай дотоодын боловсон хүчнийг бий болгох зорилгоор Оюу Толгой компани нь боловсрол, сургалтанд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхлээд байна. Үүнд:

- Таван жилийн сургалтын стратеги, төлөвлөгөө
- 5 жилийн хугацаанд хэрэгжих 200 оюутны тэтгэлэгт хөтөлбөр
- Өмнийн Говийн бүсийн Хөгжлийн Зөвлөлийг байгуулах
- Олон улсын сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх

2010 оны 7-р сард Оюу Толгой ХХК болон Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам мэргэжлийн болон тусгай мэргэжлийн сургалт, боловсролын төвүүд, хөтөлбөрүүдийг дэмжих Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Оюу Толгой ХХК ирэх таван жилийн хугацаанд дээрх хөтөлбөрүүдэд зориулан 78 тэрбум төгрөг (58 сая ам.доллар)-ийн хөрөнгө оруулалт хийнэ. Энэхүү хөрөнгө оруулалт нь цаашид Оюу Толгой болон Монгол улс дахь бусад уул уурхайн төсөлд ажиллах өндөр чадвартай боловсон хүчнийг бий болгоход оршино.

## ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ

Оюу Толгой ХХК нь байгаль орчин, өөрийн ажилтан ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарч, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, чин шударгаар үйл ажиллагаагаа явуулахыг эрхэмлэдэг.

Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа иргэдтэй хамтран ажиллаж, хууль дүрэм, ёс заншлыг эрхэмлэн сахиж, өөрийн хийж буй хөрөнгө оруулалтаар Монгол улс, Монгол улсын иргэдэд эрх тэгш үр ашгийг хангахын төлөө ажилладаг.





**Олон нийтийн мэдээлэл, харилцааны хэлтэс**

Утас: +976 11 331880 - дотуур: 3371

Факс: +976 11 331893

**Оюу Толгой ХХК**

Монгол улс,

Улаанбаатар - 12240

Сүхбаатар дүүрэг

Чингисийн өргөн чөлөө - 15

**"Моннис цамхаг"**